



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/537

Хэрлэн сум

Л.Дашнямын нэрэмжит дууны уран бүтээл
шалгаруулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.5.6.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн хөгжмийн зохиолч Л.Дашнямын нэрэмжит дууны уран бүтээл шалгаруулахад зориулж 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Хэнтийн түүх- бидэнд чухал” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ